

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.БОЛОРМААГИЙН
2024 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны дарга, Аудитын хорооны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллалаа.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл, Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо, Аудитын хорооны ээлжит болон ээлжит бус хурлуудад оролцож холбогдох тогтоолын төсөл, асуудалд саналаа өгч ажилласан.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус дараах өдрүүдийн хуралд оролцов.

- 1.1. 2024.07.15-ны өдөр;
- 1.2. 2024.07.16-ны өдөр;
- 1.3. 2024.07.30-ны өдөр;
- 1.4. 2024.09.02-ны өдөр;
- 1.5. 2024.09.17-ны өдөр;
- 1.6. 2024.10.03-ны өдөр;
- 1.7. 2024.10.15-ны өдөр;
- 1.8. 2024.10.17-ны өдөр;
- 1.9. 2024.11.04-ний өдөр;
- 1.10. 2024.11.27-ны өдөр;
- 1.11. 2024.12.12-ны өдөр;
- 1.12. 2024.12.20-ны өдөр.

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууь, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан, хараат бус гишүүний хувьд шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

1. ХХБ-ны 2024 оны санхүүгийн тайланг баталгаажуулах хараат бус аудитын байгууллагыг сонгох;
2. ХХБ-ны хуримтлагдсан ашгаас ногдол ашиг хуваарилах тухай;
3. ХХБ-ны улирал жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан;
4. Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж, гүйцэтгэлтэй танилцах;
5. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
6. ХХБ-ны Чанаргүй активыг бууруулах стратегийн гүйцэтгэлийн тайлан;
7. ХЭ-ийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
8. ХХБ-ны Хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай;
9. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг дэмжин баталгаажуулах тухай;
10. Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татах тухай;
11. ЭУХ-ны ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай;
12. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх журам болон ХХБ-ны харилцагчий таньж мэдэх нарийвчилсан ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулах;

13. ГЗТОрлогч томилох зэрэг болно.

Дээрх гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд Хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргахад анхаарч, өөрийн саналаа өгч ажилласан.

Тайлант хугацаанд 6 удаа ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хуралд гишүүний хувиар оролцон ГЗТО-ийн томилгоо, ГЗ-ийн үйл ажиллагааны тайлан, Төлөөлөгчийн газрын дарга түр томилох, хараат бус гишүүний чөлөөлөх хүсэлтэй танилцах асуудалд саналаа өгсөн. Мөн 2 удаа ТУЗ-ийн дэргэдэх АХ-ны хурлаар танилцуулсан ХХБ-ны улирлын санхүүгийн үзүүлэлтийн мэдээлэл, ДАГ-ын улирлын ажлын тайлантай танилцан шийдвэр гаргахад оролцсон болно.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:


Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй 4 удаагийн хэлцэлд зөвшөөрөл өгөхөд саналаа өгсөн.

ТУЗ-ийн гишүүд болон түүний дэргэдэх ажлын албаны зүгээс засаглалын тогтолцоог сайжруулах, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, эрх тэгш байдлыг хангах, МУ-д мөрдөгдөж буй хууль, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэх тал дээр ахиц дэвшил гарган ажиллаж байна гэж бодож байна.

Хараат бус гишүүний хувьд Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам, “Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам, Банкны дүрэм болон бусад холбогдох дүрэм, журмын баримт бичгүүдэд заасан зохицуулалтын хүрээнд эрх, үүргээ хэрэгжүүлэн бие даасан, хараат бус, мэргэшсэн байх зарчмыг барьж ажиллахыг чармайж ирсэн болно.

ХХБанкны ТУЗ-ийн хараат бус

гишүүн



Ж.Болормаа

2025 оны 01 сарын 07

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН
2024 оны II хагас жилийн тайлан

Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүн Ж.Дэлгэрсайхан

Миний бие тус банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн, 2021 оны 2 сараас аудитын хорооны дарга, эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажиллаж байна.

Монголбанкнаас баталсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын 5.5-д заасны дагуу өөрийн ажлыг тайлагнаж байна.

2024 оны III, IV улиралд ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон байдал:
Хүснэгт 1. Хуралд оролцсон байдал

д/д	Хурал, оролцсон ажлууд	Огноо	Оролцсон хэлбэр	Хэлэлцсэн асуудал
1	Аудитын хорооны хурал	2024.07.04	Цахим	(i) Худалдаа, хөгжлийн банк ХК (ХХБ)-ны 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үзүүлэлтийн мэдээлэл; (ii) ХХБ-ны 2024 оны санхүүгийн тайланд аудит хийх байгууллагыг сонгох тухай (Дээрх асуудлуудад зарчмын зөрүүтэй санал байхгүй.)
2	ТУЗ-ийн хурал	2024.07.03	Саналын хуудас	(i) ХХБ-ны ӨБҮХХ-д бүртгэлтэй хөрөнгийг худалдан борлуулах зөвшөөрөл олгох тухай
3	ТУЗ-ийн хурал	2024.07.16	Цахим	(i) ХХБ-ны хуримтлагдсан ашгаас ногдол ашиг хуваарилах тухай. (Дээрх асуудалд зарчмын зөрүүтэй санал байхгүй.)
4	Эрсдэлийн удирдлагын хорооны хурал	2024.07.30	Цахим	(i) ХХБ-ны 2024 оны Эрсдэлийн аппетитын 2-р улирлын тайлан
5	ТУЗ-ийн хурал	2024.07.30	Цахим	(i) ХХБ-ны 2024 оны эхний хагас жилийн тайлан; (ii) “Чанаргүй активыг бууруулах стратеги - 2024”-ийн хагас жилийн гүйцэтгэлийн тайлан; (iii) ХХБ-ны 2024 оны санхүүгийн тайланд аудит хийхбайгууллага сонгох тухай; (iv) Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд өөрчлөлт оруулах тухай; (v) ХХБ-ны Хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай; (vi) ХХБ-ны БЗХ-д бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулахтай холбоотой зөвшөөрөл олгох тухай. (Дээрх асуудалд зарчмын зөрүүтэй санал байхгүй.)

6	ТУЗ-ийн хурал	2024.09.02	Цахим	<ul style="list-style-type: none"> (i) Сонирхлын зөрчилтэй хэлцлийг дэмжин баталгаажуулах тухай; (ii) Зээлийн мэдээллийн төв ХХК-ийн хувьцааг худалдан авах тухай; (iii) Гадаад улс дахь Банкны төлөөлөгчийн газрын дарга томилох тухай; (iv) Гадаад улсын санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татах тухай. <p>(Дээрх асуудлуудад зарчмын зөрүүтэй санал байхгүй.)</p>
7	Эрсдэлийн удирдлагын хорооны хурал	2024.09.09	Цахим	<ul style="list-style-type: none"> (i) ХХБанкны Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай
8	ТУЗ-ийн хурал	2024.09.17	Саналын хуудас	<ul style="list-style-type: none"> (i) ХХБ-ны Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай; (ii) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх журам болон ХХБ-ны харилцагчийн таньж мэдэх үйл ажиллагаа, харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.
9	ТУЗ-ийн хурал	2024.10.03	Саналын хуудас	<ul style="list-style-type: none"> (i) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл хүсэх тухай; (ii) ХХБ-ны БЗХ-д бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулахтай холбоотой зөвшөөрөл олгох тухай.
10	Эрсдэлийн удирдлагын хорооны хурал	2024.10.15	Цахим	<ul style="list-style-type: none"> (i) ХХБ-ны 2024 оны Эрсдэлийн аппетитын 3-р улирлын тайлан
11	ТУЗ-ийн хурал	2024.10.15	Саналын хуудас	<ul style="list-style-type: none"> (i) ХХБ-ны БЗХ-д бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгүүдийг худалдан борлуулахтай холбоотой зөвшөөрөл олгох тухай (ii) Банкны Дижитал шилжилт хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч томилох;
12	ТУЗ-ийн хурал	2024.10.17	Цахим	<ul style="list-style-type: none"> (i) ХХБ-ны 2024 оны 3-р улирлын гүйцэтгэл; (ii) Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлан; (iii) Хаалттай хүрээнд өрийн бичиг гаргах тухай; (iv) ХХБ-ны ажилтнуудын орон тоог нэмэгдүүлэх тухай; (v) Сонирхлын зөрчилтэй хэлцлүүд хийх зөвшөөрөл хүсэх тухай. <p>(Дээрх асуудлуудад зарчмын зөрүүтэй санал байхгүй.)</p>
13	Аудитын хороо	2024.11.04	Цахим	<ul style="list-style-type: none"> (i) Дотоод аудитын газар (ДАГ)-ын 2024 оны хагас жилийн болон 2024.03 улирлын ажлын тайлантай танилцав. Гишүүдээс өгч байсан сайжруулалтын саналуудыг анхаарч ажлын тайландаа тусгаж явахыг ДАГ-т даалгав.

14	ТУЗ-ийн хурал	2024.11.04	Саналын хуудас	(i) ТУЗ-ийн хараат бус гишүүнээс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн түүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх
15	Аудитын хороо	2024.11.04	Цахим	(i) ДАГ-ын 2024 оны хагас жилийн болон 2024.03 улирлын ажлын тайлантай танилцав. Гишүүдээс өгч байсан сайжруулалтын саналуудыг анхаарч ажлын тайландаа тусгаж явахыг ДАГ-т даалгав.
16	ТУЗ-ийн хурал	2024.11.27	Саналын хуудас	(i) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ХХБ-ны журмын Хавсралт 2 “Гадаад шилжүүлэг хийхийг хориглосон улсын жагсаалт”-д өөрчлөлт оруулах тухай
17	ТУЗ-ийн хурал	2024.12.12	Саналын хуудас	(i) Хаалттай хүрээнд өрийн бичиг гаргах тухай;
18	ТУЗ-ийн хурал	2024.12.20	Цахим	(i) Банкны 2025 оны стратеги болон санхүүгийн төсөв батлах тухай; (ii) Зээлийн эрсдэлийн болон авлагын эрсдэлийн сангаас зээл болон авлага хаах тухай; (iii) Хөрөнгө худалдан борлуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгох тухай; (iv) ТУЗ-ийн харьяаны нэгжүүдэд хамаарах журмын тухай; (v) “ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх журам”-ыг батлуулах тухай (vi) “ХХБ-ны 2025 онд баримтлах эрсдэлийн аппетит”-ыг батлуулах тухай. (Дээрх асуудлуудад зарчмын зөрүүтэй санал байхгүй.)

Тэмдэглэл:

2024 оны сүүлийн хагас жилд хуралд оролцохдоо дараах чиглэлээр асуулт асуух, санал, зөвлөмж хэлэх, үүрэг даалгавар өгөх байдлаар ажиллалаа. Үүнд:

- Банкны үйл ажиллагааны тайлан, үр дүнтэй холбоотой асуудлаар;
- Аудитын хорооны тайлан, гүйцэтгэл, төлөвлөлтийн асуудлаар;
- Банкны 2024 оны 02, 03 дугаар улирлын МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагааны тайлан;
- Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журамд өөрчлөлт оруулах асуудал;
- ТУЗ-н дэргэдэх хороодын нарийн бичгийг томилох асуудал.

Банкны үйл ажиллагаатай холбоотой дээрх гол асуудлууд болон ДАГ, Аудитын хорооны үйл ажиллагаа, тайлагнал, үр дүнгийн хяналт, шинжилгээг сайжруулах чиглэлд ТУЗ-ийн гишүүний чиг үүргийг хэрэгжүүлж ажиллалаа.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл

2024 оны сүүлийн хагас жилд дараах сонирхлын зөрчилтэй хэлцлүүд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэгдэж, тухайн хурал бүрт өөрийн саналыг өгч оролцлоо. Үүнд:

- “Монголын Ипотекийн корпораци ОССК” ХХК-тай байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг дэмжин баталгаажуулах;
- “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК-тай “Байгууллагын бизнес кредит карт эзэмших гэрээ” байгуулах;
- “Монголын Ипотекийн корпораци ОССК” ХХК-тай “Хамтран ажиллах гэрээ” байгуулах;
- “Нэйшнл Ньюс корпорэйшн” ХХК болон “Аурум Металс” ХХК-тай “Түрээсийн гэрээ” байгуулах;
- “Ти Ди Би Капитал” ХХК болон “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК-тай “Түрээсийн нэмэлт гэрээ” байгуулах.

Дээрх сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хэлэлцэх явцад ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргийн хүрээнд хууль эрх зүйд нийцтэй байдал, Монголбанкны тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах байдал, комплайнсын хүрээнд нийцтэй зэргийг тодруулж, тайлбар авч ажиллалаа.

ТУЗ, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Аудитын хорооны даргаар ажиллахдаа Компанийн хууль, Банкны тухай хууль, Монголбанкны журам, ХХБ-ны дүрмийг мөрдлөг болгон банкны үйл ажиллагаатай холбоотой ТУЗ, Гүйцэтгэх Удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зэрэг ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

Худалдаа Хөгжлийн Банкны
ТУЗ-ийн хараат бус гишүүн:



Ж .Дэлгэрсайхан

2025 оны 01 сарын 15

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН З.НАРАНТУЯАГИЙН
2024 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүн, 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, 2023 оны 8 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 2024 оны 11-р сарын 4-ний өдрийг дуустал хугацаанд Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр тус тус ажиллалаа.

Холбогдох хууль тогтоомж болон Банкны тухайн үеийн нөхцөл байдалд тулгуурлан тайлант хугацаанд ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурал, Эрсдэлийн удирдлагын хороо, Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны дараах хурлуудад оролцож, холбогдох шийдвэрүүд гаргахад саналаа өгч ажилласан.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

- 1.1. 2024.07.15-ны өдөр
- 1.2. 2024.07.16-ны өдөр;
- 1.3. 2024.07.30-ны өдөр;
- 1.4. 2024.09.02-ны өдөр;
- 1.5. 2024.10.03-ны өдөр;
- 1.6. 2024.10.17-ны өдөр.

2. Эрсдэлийн удирдлагын хорооны хурал

- 2.1. 2024.07.30-ны өдөр;
- 2.2. 2024.09.09-ний өдөр;
- 2.3. 2024.10.15-ны өдөр.

3. Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хурал

- 3.1. 2024.08.06-ны өдөр;
- 3.2. 2024.08.26-ны өдөр
- 3.3. 2024.10.11-ний өдөр.

Энэхүү хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

ТУЗ-ийн хурлаар:

1. Банкны хуримтлагдсан ашгаас ногдол ашиг хуваарилах тухай;
2. Банкны үйл ажиллагаа, санхүүгийн улирлын тайлан;
3. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх эсэх хүсэлтийг шийдвэрлэх;

4. Төлөөлөгчийн газрын дарга томилох тухай;
5. Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татах тухай;
6. Худалдаа, хөгжлийн банкны үндсэн хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө, өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгүүдийн зах зээлийн үнийг тогтоож, худалдан борлуулах зөвшөөрөл олгох.

Эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар:

1. ЭУХ-ны ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай;
2. Банкны 2024 оны Эрсдэлийн аппетитын улирлын гүйцэтгэлтэй танилцсан.

Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хурлаар:

1. ГЗГО томилох тухай;
2. Төлөөлөгчийн газрын дарга түр томилох тухай;
3. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудлыг дэмжсэн саналтайгаар ТУЗ-д танилцуулах.

Дээр дурдсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд хууль тогтоомжид нийцсэн шийдвэрүүд байсан гэж үзэж байна.

Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд өөрийн саналаа тусгаж ажилласан. Тайлант хугацаанд дөрвөн сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл хүссэн асуудалд санал өгсөн бөгөөд зарчмын зөрүүтэй санал байгаагүй, энэхүү шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн шийдвэр байсан. Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудал ТУЗ-ийн хурлаар хэлэлцэгдээгүй.

ТУЗ түүний дэргэдэх хороодын дарга, -гишүүнээр ажиллахдаа төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь улс төрийн, том хувь нийлүүлэгчдийн нөлөөлөл болон бусад гаднын зохисгүй нөлөөнөөс үл хамааран Худалдаа, хөгжлийн банкны эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавьж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Банкны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч Банк болон хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэн ажиллахыг удирдлага болгосон болно.

Худалдаа, хөгжлийн банкны
ТУЗ-ийн хараат бус гишүүн



З.Нарантуяа

2025 оны 1 дүгээр сарын 8